

МОНГОЛБАНКНЫ ШАГНАЛЫН ЖУРАМ

(Шинэчилсэн найруулга)

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Монгол Улсын төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, санхүүгийн зах зээл, банк, санхүүгийн системийг бэхжүүлэх, банк хоорондын төлбөр тооцоог зохион байгуулах, үндэсний эдийн засгийг хөгжүүлэхэд идэвх зүтгэл гарган үр бүтээлтэй ажилласан банк, санхүүгийн системийн ажилтныг Монголбанкны шагналаар шагнахад энэхүү журмыг мөрдөнө.

1.2.Монгол Улсын төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх, банк, санхүүгийн системийг бэхжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсан төрийн болон бусад байгууллагын ажилтныг Монголбанкны шагналаар шагнаж болно.

1.3.Энэхүү журмын зорилго нь Монголбанкны шагналын төрөл, дагалдах мөнгөн шагналын хэмжээ, шагнал олгох зарчим, нөхцлийг тогтоох, шагналд тодорхойлох, шийдвэрлэх болон шагналтай холбогдсон бусад харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Шагналын төрөл

2.1.Монголбанкны шагнал нь Хүндэт дэвтэрт алдаршуулан бичих, “Санхүү, банкны тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, Хүндэт жуух бичиг, Баярын бичиг, “Оны тэргүүний ажилтан” өргөмжлөл, өргөмжлөл, аялалын эрхийн бичиг, тусгай мөнгөн шагнал, үнэ бүхий зүйл гэсэн төрөлтэй байна.

2.2.Хүндэт дэвтэр нь Монгол Улсад банкны байгууллага үүсч хөгжсөн түүхэн замналыг товч дурдсан оршил хэсэг, банкны байгууллагыг хөгжүүлэн бэхжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан шилдэг тэргүүний ажилтны зураг, доод хэсэгт нь хөдөлмөр бүтээлийн амжилтаас дурдсан товч тодорхойлолт, алдар гавьяаг нь мөнхжүүлэн үлдээх гоёмсог хуудас бүхий хилэн хавтастай байна. Хүндэт дэвтэрт бичигдсэн тухай дурсгалын гэрчилгээнд Монголбанкны билэг тэмдэг, “Хүндэт дэвтэрт бичигдсэн тухай гэрчилгээ”, “Монгол Улсад банкны байгууллагыг хөгжүүлэх үйлст оруулсан хувь нэмрийг тань үнэлж, Монголбанкны Хүндэт дэвтэрт алдаршуулан бичиж гэрчилгээ олгов” гэсэн үгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн гарын үсэг зурах зайтай хэвлэсэн байна. Гэрчилгээний талархлын үг, “дугаар, огноо, танаа, Улаанбаатар хот” гэсэн үгийг хараар, бусад үгийг алтан бронзоор хэвлэсэн байна.

2.3.“Санхүү, банкны тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг нь гонзгой хэлбэртэй, Монголбанкны билэг тэмдэгтэй, хүндэт тэмдгийн оноосон нэрийг монгол үсгээр бичсэн байна.

2.4.Хүндэт жуух бичиг нь хилэн хавтастай, төрийн сүлдтэй байх бөгөөд дотор талын зүүн хэсэгт соёмбо, баруун талд Монголбанкны билэг тэмдэг, түүний доод хэсэгт

“Монголбанкны Хүндэт жуух бичиг”, “банк, санхүүгийн байгууллагыг хөгжүүлэх үйлст оруулсан хувь нэмрийг тань үнэлж Монголбанкны Хүндэт жуух бичгээр шагнав.” гэсэн талархлын үг, Монголбанкны Ерөнхийлөгчийн гарын үсэг зурах зайтай хэвлэсэн байна. Хүндэт жуух бичгийн талархлын үг, “дугаар, огноо, танаа, Улаанбаатар хот” гэсэн үгийг хараар, бусад үгийг алтан бронзоор хэвлэнэ.

2.5.Баярын бичиг нь Монголбанкны билэг тэмдэг, түүний доод хэсэгт “Монголбанкны Баярын бичиг” гэсэн үгийг Монголбанкны Ерөнхийлөгчийн гарын үсэг зурах зайтай алтан бронзоор, баярын бичгийн “дугаар, танаа, огноо, Улаанбаатар хот” гэсэн үгийг хараар хэвлэсэн байна.

2.6.“Оны тэргүүний ажилтан” өргөмжлөл нь Монголбанкны билэг тэмдэг, түүний доод хэсэгт “ оны тэргүүний ажилтан” гээд тухайн онд гаргасан ажлын амжилтын талаар товч дурдаж, Монголбанкны Ерөнхийлөгчийн гарын үсэг зурах зайтай хэвлэсэн байна. Өргөмжлөлийн “дугаар, танаа, Улаанбаатар хот” гэсэн үгийг хараар, бусад үгийг алтан бронзоор хэвлэнэ.

2.7.Монголбанкны өргөмжлөл нь дээд хэсэгтээ Монголбанкны билэг тэмдэг, түүний доод хэсэгт “Монголбанкны өргөмжлөл”, тухайн арга хэмжээ, уралдаан тэмцээнд гаргасан амжилтын талаар товч дурдаж, Монголбанкны Ерөнхийлөгч гарын үсэг зурах зайтай хэвлэсэн байна. Өргөмжлөлийн доор “дугаар, огноо, Улаанбаатар хот” гэсэн үгийг хараар, бусад үгийг мөнгөн бронзоор хэвлэнэ.

2.8.Хүндэт дэвтрийн гэрчилгээ, “Санхүү, банкны тэргүүний ажилтан” хүндэт тэмдгийн үнэмлэх, Хүндэт жуух бичиг, “Оны тэргүүний ажилтан” өргөмжлөл, Баярын бичиг, өргөмжлөлд Монголбанкны Ерөнхийлөгч гарын үсэг зурж, тамга дарсан байна.

2.9.Монголбанкны шагналыг дараах мөнгөн шагнал дагалдана. Үүнд:

2.9.1.Хүндэт дэвтэрт бичигдэх 500,000 (таван зуун мянган) төгрөг;

2.9.2.“Санхүү, банкны тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр шагнахад 300,000 (гурван зуун мянган) төгрөг;

2.9.3.Хүндэт жуух бичгээр шагнахад 200,000 (хоёр зуун мянган) төгрөг;

2.9.4.Баярын бичгээр шагнахад 75,000 (далан таван мянган) төгрөг;

2.9.5.“Оны тэргүүний ажилтан” өргөмжлөлөөр шагнахад зөөврийн компьютер;

2.9.6.Өргөмжлөлөөр шагнахад тухайн үеийн уралдаан тэмцээн, арга хэмжээний зардлын төсөвт тусгагдсан мөнгөн шагнал;

2.9.7.Үнэ бүхий зүйлээр шагнахад 75,000 (далан таван мянган) төгрөг;

2.9.8.Тусгай мөнгөн шагналын хэмжээг Тамгын газраас тухайн үед санал боловсруулж Монголбанкны Ерөнхийлөгчид танилцуулж тогтооно.

Гурав. Шагнал олгох зарчим, нөхцөл

3.1.Энэхүү журмын 2.2, 2.3-т зааснаас бусад Монголбанкны шагналыг нэг ажилтанд давхардан олгож болно.

3.2.Банк, санхүүгийн байгууллагын ажилтан болон банк, санхүүгийн мэргэжлээр банкны байгууллагад 20-иос дээш жил үр бүтээлтэй ажилласан ахмад настныг “Санхзз, банкны тэргүүний ажилтан” хүндэт тэмдэг, Хүндэт жуух бичиг, Баярын бичгээр тус тус шагнаж болно.

3.3.“Хүндэт дэвтэр”-т Монгол Улсад банкны байгууллагыг хөгжүүлэн бэхжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулж, онцлон тэмдэглэхүйц ажлын амжилт гаргаж, банкны байгууллагад 30-аас дээш жил ажилласан шилдэг тэргүүний ажилтныг алдаршуулан бичнэ.

3.4.“Санхүү, банкны тэргүүний ажилтан” хүндэт тэмдгээр банкны байгууллагыг хөгжүүлэх үйлст хувь нэмэр оруулж, ажлын амжилт гаргаж, банкны байгууллагад 10-аас дээш жил ажилласан, банкны байгууллагын шилдэг тэргүүний ажилтныг шагнаана.

3.5.“Хүндэт жуух бичиг”-ээр банк, санхүүгийн байгууллагыг хөгжүүлэх үйлст хувь нэмэр оруулж, банк, санхүүгийн байгууллагад 5-аас дээш жил идэвх санаачилга гарган амжилттай ажиллаж байгаа тэргүүний ажилтныг шагнаана.

3.6.“Баярын бичиг”-ээр эрхэлсэн ажилдаа идэвх санаачлага гарган үр бүтээлтэй ажиллаж байгаа тэргүүний ажилтныг шагнаана.

3.7.“Оны тэргүүний ажилтан” өргөмжлөлийг Монголбанкны төв аппаратын болон орон нутаг дахь хэлтэс (салбар)-ийн гүйцэтгэх ажилтнуудаас тухайн онд ажлын амжилт, хөдөлмөр зүтгэлээрээ шалгарсан шилдэг тэргүүний ажилтанд олгоно.

3.8.“Өргөмжлөл”-өөр урлаг, спорт, олон нийтийн бусад арга хэмжээнд идэвх зүтгэл гарган амжилттай оролцсон баг бүрэлдэхүүн, ажилтан болон харилцагч, хамтран ажилладаг байгууллагын хамт олныг шагнаана.

3.9.“Аялалын эрхийн бичиг”-ээр эрхэлсэн ажилдаа идэвх санаачлага гарган үр бүтээлтэй ажиллаж байгаа Монголбанкны төв аппаратын болон орон нутаг дахь хэлтэс (салбар)-ийн ажилтныг шагнаана.

3.10.“Тусгай мөнгөн шагнал”-аар Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийн болон Монголбанкны дотоод ажлын төлөвлөгөө, чиг үүргийг ханган биелүүлэхэд сайн ажилласан удирдах ажилтан (газар, алба, хэлтэс, төв, орон нутаг дахь хэлтэс, салбарын захирал)-г шагнаана.

3.11.“Үнэ бүхий зүйл”-ээр эрхэлсэн ажилдаа идэвх, санаачилга гарган үр бүтээлтэй ажиллаж байгаа ажилтныг шагнаж урамшуулна.

3.12.Монголбанкны шагналаар тухайн ажилтныг шагнахад дараах шалгуурыг баримтална. Үүнд:

- 3.12.1.Ажлын үр дүн, ажил үүргээ тогтмол, чанартай биелүүлсэн байдал;
- 3.12.2.Мэргэжлийн ур чадвар;
- 3.12.3.Ажилтны ёс зүй, байгууллагын соёлыг сахин биелүүлж буй байдал;
- 3.12.4.Шагнал хоорондын хугацаа;
- 3.12.5.Шагнагдсан байдал.

3.13.Монголбанкны ажилтныг “Баярын бичиг”, “Үнэ бүхий зүйл”-ээр шагнахад шагнал хоорондын хугацаа 1-2 жил байна.

Дөрөв. Шагналд тодорхойлох, материалыг хүлээн авах

4.1.Монголбанкны газар, бие даасан нэгж, орон нутаг дахь хэлтэс (салбар), банк, бусад байгууллага нь тухайн ажилтныг Монголбанкны шагналд тодорхойлохдоо ажил байдлын тодорхойлолт, хамт олны хурлын протокол, анкет (энэхүү журмын хавсралт)-ийг албан бичгээр Монголбанкны Тамгын газарт ирүүлнэ.

4.2.Ажил байдлын тодорхойлолтод шагналд нэр дэвшигч эрхэлсэн ажилдаа ямар санаачилга, бүтээл гаргасан, түүнийг хэрэгжүүлснээр банкны байгууллагыг хөгжүүлэх үйлст ямар ахиц дэвшил гарсныг баримтаар дурдаж, шагналын талаар саналаа бичиж, газар, бие даасан нэгж, орон нутаг дахь хэлтэс (салбар), банк, бусад байгууллагын захирал (дарга) гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан байна.

4.3.Банк, санхүү болон бусад байгууллага нь өмнө нь тухайн байгууллагын шагналаар шагнагдаж байсан, Монголбанкны шагналаар шагнуулах шалгуурыг хангасан ажилтныг тодорхойлно.

4.4.Монголбанкны шагналын нэр хүндийг бэхжүүлэх, өсгөх зорилгоор хэт олон ажилтныг шагнуулахаар тодорхойлохыг хориглоно.

4.5.Үндэсний их баяр наадам, жилийн эцсийн ажлын үр дүн, Монгол Улсад банкны байгууллага үүсч хөгжсөний болон банкны байгууллагын үүсэн байгуулагдсаны тэгш ойн баярыг тохиолдуулан тус тус шагналд тодорхойлсон материалыг Монголбанкны Тамгын газарт 30 хоногийн өмнө ирүүлсэн байна.

4.6.Бусад тохиолдолд шагналд тодорхойлсон нэр дэвшигчийг хэзээ шагнуулах асуудлыг Тамгын газар шийдвэрлэнэ.

4.7.Монголбанкны шагналын нэр хүндийг хадгалж, шагналыг оновчтой олгох зорилгоор Тамгын газар нь ирүүлсэн шагналын материалыг хянаж, саналаа удирдлагад танилцуулж шийдвэрлүүлнэ.

4.8.Монголбанкны шагналыг Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар олгох бөгөөд өргөмжлөл, аялалын эрхийн бичгээр шагнаж урамшуулахад энэхүү журмын 4.1-т заасан материалыг шаардахгүй болно.

4.9.Монголбанкны ажилтныг төрийн дээд шагналаар шагнуулахаар нэр дэвшүүлсэн нөхцөлд холбогдох материалыг Тамгын газар судлан үзэж, саналын хамт Захирлуудын зөвлөлийн хуралд танилцуулан зохих журамд заасны дагуу уламжилна.

4.10.Энэхүү журмын 3.3, 3.4, 3.5-д заасан шагналыг тухайн ажилтанд ёслол хүндэтгэлтэй гардуулна.

Тав. Шагналын дагалдах мөнгийг гаргах

5.1.Монголбанкны Нийгмийн хөгжлийн сангаас Монголбанкны ажилтны болон гэрээгээр харуул хамгаалалтын ажил гүйцэтгэж байгаа алба хаагчийн шагналын дагалдах мөнгөн шагналыг гаргана.

5.2.Банк, санхүү, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжээс шагнагдсан ажилтны шагналын дагалдах мөнгөн шагналыг шагналд тодорхойлсон тухайн

байгууллага нь гаргана.

5.3.Засгийн газрын салбарын болон бусад шагналаар шагнуулсан Монголбанкны ажилтны шагналын дагалдах мөнгийг Монголбанкнаас шагнуулахаар нэр дэвшүүлж тодорхойлсон нөхцөлд Нийгмийн хөгжлийн сангаас зохих журмын дагуу гаргана.

Зургаа. Шагналыг бүртгэх

6.1.Монголбанкны шагналаар шагнагдсан тухай бүртгэлийг шагнал тус бүрээр хөтөлж, баяжилтыг тухай бүр хийнэ.

6.2.Шагнагдсан ажилтны материалыг архивын нэгж болгон товъёоглон оны эцэст архивт шилжүүлнэ.

6.3.Шагнагдаагүй ажилтны материалыг албан бичгийн хамт тухайн байгууллагад нь буцаана.

Долоо. “Санхүү, банкны тэргүүний ажилтан” хүндэт тэмдгийг нөхөн олгох

7.1.Монголбанкнаас шагнасан “Санхүү, банкны тэргүүний ажилтан” хүндэт тэмдгийг үрэгдүүлсэн, эвдэж гэмтээсэн тохиолдолд шагналын эзний хүсэлтийг үндэслэн зохих үнээр нь нөхөн олгож болно.

7.2.Хүндэт тэмдгийг нөхөн авахыг хүсвэл үрэгдүүлсэн, эвдэж гэмтээсэн нөхцөл, шалтгааныг тодорхой бичсэн өргөдөл, тэмдгийн зохих үнийг Монголбанкны холбогдох дансанд тушаасан баримт, эвдэрч гэмтсэн тэмдгийн хамт Монголбанкны Тамгын газарт ирүүлнэ.

7.3.Тамгын газар өргөдөл, холбогдох материалыг судалж үзээд зохих бүртгэл хөтлөн тэмдгийг олгоно.

МОНГОЛБАНК

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны дугаар сарынны
өдрийн дугаар тушаалаар батлагдсан
“Монголбанкны шагналын журам”-ын хавсралт

МОНГОЛБАНКНЫ ШАГНАЛААР ШАГНУУЛАХ
ХҮНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

1. Овог _____
2. Нэр _____
3. Төрсөн огноо _____
4. Хүйс _____
5. Үндсэн угсаа _____
6. Үндсэн захиргаа _____
7. Одоогийн харьяалал _____ аймаг /хот/, _____ сум /дүүрэг/,
_____ баг /хороо/
8. Нийгмийн байдал _____
9. Регистрийн дугаар _____
10. Боловсрол _____
11. Ажиллаж буй салбар _____
12. Мэргэжил _____
13. Одоогийн албан тушаал _____
14. Ажиллаж байсан байгууллагын нэр _____
Хугацаа Албан тушаал
/хэдээс хэдэн онд/
Хугацаа Юуны учир
/он/
15. Урьд нь _____
шагнагдаж байсан эсэх _____
16. Одоо шагнуулах гэж буй үндэслэл _____
17. Одоо шагнуулах гэж буй шагналын нэр _____
18. Хамт олны санал /хувиар/ _____
19. Байгууллагын санал _____
20. Өөрчилсөн шалтгаан _____
/хамт олны саналыг өөрчлөөгүй бол
хоосон орхино./